



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/797

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 5 дугаар хуралдааны халдвар хамгааллын зардалд 1 113 400 төгрөг, Баруун бүсийн хурдан морины уралдааны өргөмжлөл хийлгэх зардалд 292 500 төгрөг, Аймгийн сурын харвааны Аймгийн мэргэн цолны тэмдэг, үнэмлэх хийлгэх зардалд 192 500 төгрөг, 2022 оны төсвийн шинэчлэлт сургалт, хэлэлцүүлгийн арга хэмжээнд 299 200 төгрөг, аймгийн Засаг даргын орлогч дарга сумдад ажилласан зардалд 239 000 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 2 136 600 төгрөг /Хоёр сая нэг зуун гучин зургаан мянга зургаан зуун/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

